

**Өлгий сумын ЗДТГ-ын 04-р сарын 05-с эхлэн 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл**

2019-04-11

- Хотын төвд болон гэр хороололд шинээр тавигдах хатуу хучилттай авто замын трасс чөлөөлөх ажлын хэсгийг засаг даргын захирамжаар байгуулж ажилд оруулаад байна.
- Сумын бүсчилсэн хөгжлийн бодлогод зарим дэд бүтцийн байгууллагуудаас санал авах хүсэлт илгээв.
- Инженерийн шугам сүлжээ бүхий ЦШСГазар, Холбоо, СУАТ, Эрчим компаниудад шугам сүлжээний бүрэн бүтэн байдал, худгийн тагуудыг стандартын дагуу байлгах талаар албан тоотоор үүрэг даалгавар өгч ажиллав.
- Аймгийн МХГазраас болон Өлгий сумын засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу ЗДТГазрын даргаар батлуулсан ажлын удирдамж, хуваарийг хэрэгжүүлж “Хоггүй Өлгий” 5 хоногийн аяны хүрээнд Өлгий хотын бүх ААНэгж, албан байгууллага, багийн ард иргэдийг хамааруулж эзэнтэй хог хаягдлыг ачуулах, их цэвэрлэгээ хийлгэсэн.
- Аяны ажлын хүрээнд эзэнгүй хурай хог хаягдлын хэмжээг тогтоож өлгий сумын ЗДТГазарт танилцуулж, санхүүгийн асуудлыг шийдэх талаар ИТХ-ын чуулганд оруулах материалыг бүрдүүлж танилцуулав.
- Төрийн албаны зөвлөлд Өлгий сумын төрийн захиргааны албан хаагч нарын судалгааг зохих маягтын дагуу гаргаж хүргүүлэв.
- Аймгийн төвд шилийг цуглуулах 2 цэгийг АПУ ХХК-тай хамтран байгуулах талаар АПУ компани холбогдох хүмүүстэй ярьж ажиллаж байгаа.
- Аймгийн хэмжээнд явагдаж буй аяны арга хэмжээнүүдэд идэвх санаачилгатай оролцож, тайлан, судалгаа мэдээг цаг тухайд нь холбогдох төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлж ажиллаж байна.
- Багийн засаг дарга нар цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.
- Цагдаагийн хэсгийн байцагч нар Өлгий сумын багийн иргэдтэй уулзаж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хөршийн холбооны ахлагч томилон сургалт зохион байгуулав.

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ